

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Байгууллагын мэдээлэл	3
1.2. Төслийн мэдээлэл	3
1.2.1. Уурхайн одоогийн байдал	4
1.2.2. Геологийн үлдэгдэл нөөц болон үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	4
1.2.3. Уурхайн жилийн хүчин чадал	5
1.2.4. Уулын ажлын төлөвлөлт	5
1.2.5. Уурхайн ашиглалтын систем	6
1.2.6. Баяжуулах үйлдвэр	6
1.2.7. Дэд бүтэц	6
1.3. Төслийн 2026 оны уулын ажлын төлөвлөгөө	7
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа	12
3.2. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл	14
4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	16
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
4.3. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	19
4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
4.9. Тухайн жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	30
ДҮГНЭЛТ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

Хүснэгт 1.	Ил уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 2.	Ашиглалтын жилүүдийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ	5
Хүснэгт 3.	Ашиглалтын эхний жилийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ	7
Хүснэгт 4.	Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	12
Хүснэгт 5.	Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт	14
Хүснэгт 6.	2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	16
Хүснэгт 7.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 8.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 9.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 10.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 11.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 12.	2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
Хүснэгт 13.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	30
Хүснэгт 14.	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

Зураг 1.	Төслийн байршил	3
Зураг 2.	Ил уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлт	7

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1 Байгууллагын мэдээлэл

Төслийн нэр:	“Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэг дэх Хөөт-3 ордыг ил аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Монгол тунжөн майнинг инвестмент групп” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019090126, Регистрийн дугаар: 6454763, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020899
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, байршил:	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 5-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө, Эко интернэйшнл тауэр 15 давхрын зүүн жигүүр
Утас:	Гүйцэтгэх захирал, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Luo Wei. Утас: 99999219, 88008059
Төслийн байршил:	Дундговь аймгийн Баянжаргалан сум, Энгэр-Ус багийн нутагт Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэг

1.2. Төслийн мэдээлэл

“Монгол тунжөн майнинг инвестмент групп” ГХОХХК нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-020899 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хөөт нэртэй 65.33 га талбайг хамарсан нүүрсний ордыг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн 2025 оны 07 сарын 24-ний өдрийн 417-р шийдвэрээр “Хуучин андууд” ХХК-иас шилжүүлэн авсан.

Зураг 1. Төслийн байршил



1.2.1. Уурхайн одоогийн байдал

Уурхай нь 2025 оны байдлаар III-4b давхраасны C-1 блокоос 18.35 мян.тн, III-4a давхраасны B-1 блокоос 77.92 мян.тн, III-3b давхраасны B-2 блокоос 446.99 мян.тн, III-3a давхраасны C-1 блокоос 30.34 мян.тн, III-2 давхраасны C-1 блокоос 18.66 мян.тн, III-1 давхраасны B-1 блокоос 2.7 мян.тн, II-3 давхраасны C-2 блокоос 0.1 мян.тн буюу нийт бодитой болон боломжтой B+C зэрэглэлээр 595.15 мян.тн нүүрс олборлосон байна.

Нийт гадаад, дотоод овоолго болон уулын ажлаар 25.37 га талбай эвдрэлд орсноос дотоод тээврийн зам, нүүрсний агуулах, барилга байгууламж 1.99 га, овоолго 8.77 га талбай, уурхай 14.61 га талбайг эзэлж байна. Уурхайн эцсийн хүрээ хязгаарыг тогтооход гадаад овоолгын урд хэсэг уурхайн эцсийн хүрээний хойд хэсгийг 40-50 м дарсан байдалтай, дотоод овоолго нь уурхайн тэлэлтэд орж байна.

1.2.2. Геологийн үлдэгдэл нөөц болон үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Хөөт-3 нүүрсний ордын хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 4,647.82 мян.тн нүүрсний үлдэгдэл нөөцтэй байна.

Ашиглалтын нөөц

Орд нь II бүлгийн орд тул бодитой B зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж боломжтой C зэрэглэлийн нөөцийг ил уурхайн хүрээ хязгаараар өртүүлэн олборлохоор ашиглалтын нөөцийн хэмжээг тооцоход 1,816.38 мян.тн нүүрс байна. Нөөцийн блокууд нь тусгай зөвшөөрлийн хилийн баруун тал, урд талд тулсан учир энэ хэсэгт бодитой (B) зэрэглэлийн нөөцөөс 777.78 мян.тн нүүрсийг олборлохгүй үлдээж байна. Нийт ил уурхайн хүрээний гадна талд 2,831.44 мян.тн нүүрс үлдэж байна.

Ашиглалтын үеийн хаягдал

Хаягдал бохирдлыг оновчтой гаргахын тулд нүүрсний давхаргын ул таазны талбайг гарган түүнээс хамааруулан хаягдал болон бохирдлын хэмжээг тооцлоо. Уурхайг ашиглах явцад нормоор дараах хаягдлууд гарна гэж үзэв:

- Нүүрсний давхаргын ул болон таазны цэвэрлэгээний үед – 10 см Хөөтийн нүүрсний ордын ашиглалтын үеийн хаягдлын нийт хэмжээ 52.71 мян.тн буюу нөөцийн 2.9 хувь нь хаягдал болно.
- Ашиглалтын үеийн бохирдол: Уурхайг ашиглах явцад нүүрсний давхаргын ул тааз болон хажуу борт, нүүрсний давхраас хоорондын хоосон чулуулаг гэх мэт нөхцөлүүдээс шалтгаалан бохирдоно.

Нийт 131.78 мян.тн хэмжээтэй бохирдол уулын ажилд нэмэгдэхээр байна. Энэ нь нөөцийн 7.3 хувьтай тэнцэж байна.

Үйлдвэрлэлийн нөөц:

Хөөт-3 нүүрсний ил уурхайн хил хязгаар дотор орших хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр

сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь 1,895.45 мян.тн нүүрс болж байна.

1.2.3. Уурхайн жилийн хүчин чадал

Ил уурхайн нүүрс олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход 4 жилийн хугацаанд олборлохоор байна.

Уулын ажлын горим:

Уурхайн үйл ажиллагаа нь тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Эхний жил бичиг баримтын бүрдлийн улмаас 07 дугаар сараас эхэлж ажиллах бол 2 дахь жилээс тасралтгүй үйл ажиллагаатай байна.

Хүснэгт 1. Ил уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	хэмжээ
1	Хуанлийн	хоног	365
2	Баяр ёслол	хоног	10
3	Засвар үйлчилгээ, сул зогсолт	хоног	36
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	319
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	24
6	Ээлжийн тоо	ш	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12
8	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх), цаг	цаг	1
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл, цаг	цаг	0.5
10	Нийт ээлж хүлээлцэх, үдийн цай, тос түлш нэмэх цаг	цаг	3
11	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	21
12	Цаг ашиглалт		0.88
13	Жилд ажиллах нийт цаг	цаг	6,699

1.2.4. Уулын ажлын төлөвлөлт

Ил уурхай нь 1 дэх жилд 07 дугаар сараас эхлэн ажиллаж 445 мян.тн нүүрс олборлоно. 2 дахь жилээс бүрэн хүчин чадлаараа ажиллах ба уулын ажлын төлөвлөлтөөр нийт үйлдвэрлэлийн нөөцийг 4 жилийн хугацаанд олборлоно. Ашиглалтын жил бүрийн хөрс хуулалт, нүүрс олборлолт, уулын цулын хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Ашиглалтын жилүүдийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ

Ашиглалтын жил	В нөөц, мян.тн	С нөөц, мян.тн	Нүүрс олборлолт В+С, мян.тн	Хөрс хуулалт, мян.м ³				Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалтын коэффициент м ³ /тн
				Шимт хөрс	Гадаад овоолго	Дотоод овоолго	Нийт		
1 дэх жил	272.19	172.81	445.00	44.0	1,881.6	-	1,925.6	2,230.4	4.33
2 дахь жил	162.70	437.30	600.00	30.5	2,649.6	1,188.5	3,868.6	4,279.6	6.45
3 дахь жил	208.77	391.23	600.00	22.5	1,519.0	2,314.6	3,856.1	4,267.0	6.43
4 дэх жил	115.55	134.90	250.45		-	1,523.8	1,523.8	1,695.3	6.08

Нийт	759.2093	1,136.24	1,895.45	97.0	6,050.2	5,026.8	11,174.0	12,472.27	5.90
------	----------	----------	----------	------	---------	---------	----------	-----------	------

1.2.5. Уурхайн ашиглалтын систем

Уулын ажлыг авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Тэсэлгээний ажил: Орд нь гидрогеологийн хувьд шүүрлийн устай учир анфо болон эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг 7 хоногт 1 удаа тогтсон өдөр явуулахаар тооцсон бөгөөд Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр тэсэлгээг хийнэ.

1.2.6. Баяжуулах үйлдвэр

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Хөөт-3 нүүрсний ордоос бохирдолгүй таваарын нүүрс, завсрын чулуулгаар бохирдсон нүүрс гэсэн 2 төрлийн нүүрс олборлоно. Нүүрсний шинж чанар болон экспортын нүүрсэнд тавигдах чанарын шаардлагаас хамааран зөвхөн бохирдолтой нүүрсийг хуурай аргаар нүүрснээс завсрын чулуулгийг салган баяжуулахаар төлөвлөсөн.

Хөөт-3 нүүрсний орд нь ашиглалтын үеийн шүүрлийн устай учраас орд ашиглалтын үед нүүрс тодорхой хэмжээгээр устай, чийгтэй гарч ирэх бөгөөд хуурай аргаар баяжуулах төхөөрөмжид оруулахын өмнө урьдчилан хатаах шаардлага гарч байна.

Нүүрсийг баяжуулах хэсэг нь өдөрт 2 ээлжээр, нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байх ба ажилчдын цайны цагийг 1 цаг байхаар тооцсон бөгөөд ажил эхлэх болон дуусах хугацааг 1 цагаар тооцоход бүтээлтэй ажиллах хугацаа 10 цаг байна.

1.2.7. Дэд бүтэц

Уурхайн ажилчдын хотхон: Уурхайг түшиглэн баригдах ажилчдын хотхон нь нийт 70 хүний багтаамжтай ба төв оффис болон гаднаас ирсэн зочдыг оролцуулан тооцож зохион байгуулав. Ажилчдын сууц, уурхайн удирдлагын байр, цайны газар, халуун ус, угаалга болон сэлбэг хэрэгслийн агуулахыг засаж тохижуулсан 40 тн-ын контейнероор шийдсэн.

Дулаан хангамж: Уурхайн барилга, байгууламжийн хувьд 40 тн-ийн контейнерууд байгаа бөгөөд сэрүүний улиралд цахилгаанаар халаахаар тооцсон.

Цахилгаан хангамж: Хөөт-3 нүүрсний уурхайн цахилгаан хэрэглэгчдийг дизель генератор ажиллуулж, цахилгаан эрчим хүчээр хангахаар төлөвлөлөө.

Түлшний агуулах: Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний сарын дундаж хэрэглээ 160 тн бөгөөд 14 хоног тутамд татан авалтыг хийнэ. Түлшний агуулах нь тур бүрдээ 50 тн түлш хадгалах зориулалт бүхий 2 ширхэг түлшний ёмкость байна.

Ус хангамж: Тус уурхай нь Умард говийн гүвээт – Халхын дундад талын сав газарт харьяалагдаж байна. Уурхайн хүн амын унд, ахуйн хэрэгцээ болон биологийн нөхөн сэргээлтийн усалгаанд шаардагдах усыг Баянжаргалан сумын төвийн цаг уурын станцын урд

байрлах Баянжаргалан сумын ЗДТГ-ын эзэмшлийн 2.1 л/с ундаргатай газрын доорх усны худгаас хангах ба замын усалгаанд ашиглах усыг ил уурхайгаас шавхан зайлуулах усаар хангана.

1.3. Төслийн 2026 оны уулын ажлын төлөвлөгөө

Ил уурхай нь 1 дэх жилд 07 дугаар сараас эхлэн ажиллаж 445 мян.тн нүүрс олборлоно.

Хүснэгт 3. Ашиглалтын эхний жилийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ

Ашиглалтын жил	В нөөц, мян.тн	С нөөц, мян.тн	Нүүрс олборлолт, В+С, мян.тн	Хөрс хуулалт, мян.м ³				Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалтын коэф. м ³ /тн
				Шимт хөрс	Гадаад овоолго	Дотоод овоолго	Нийт		
1 дэх жил	272.19	172.81	445.00	44.0	1,881.6	-	1,925.6	2,230.4	4.33
Нийт	272.19	172.81	445.00	44.0	1,881.6	-	1,925.6	2,230.4	4.33

Ил уурхайн дизайн: Ил уурхай нь 1 дэх жилд урд уурхайгаас 282.92 мян.тн нүүрс олборлож 995.39 мян.м³ хөрс хуулна. Хойд уурхайгаас 162.08 мян.тн нүүрс олборлож 886.17 мян.м³ хөрс хуулна. Нийт 445 мян.тн нүүрс олборлож 1,881.56 мян.м³ хөрс хуулна. Ил уурхайн гүн +1,173, 1,167 м-ийн түвшин хүрнэ.

Зураг 2. Ил уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлт



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бүс нутгийн газарзүй:

Ашигт малтмал ашиглалтын MV-020899 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэгдэх Хөөт-3” нэртэй нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км, Говь-Сүмбэр аймгаас баруун урагш 100 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 130 км, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замаас 90 км зайд 65.33 га талбайг хамран байрлана. Орд газар нь физик газар зүйн хувьд ухаа гүвээт талын хэв шинжид багтах ба Дундговь аймгийн Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нутгийн заагт буй баруун талаараа Баруун хүрийн ухаа, зүүн талаараа Талын хоолой, Талын худгийн хөндий, хойд талаараа Хар хадны толгодоор хүрээлэгдсэн Сүүдрийн хоолойн дунд буй Хөөтийн булаг орчимд оршино. Хөндийн зах орчмоор нь Хөөтийн толгод, Хар тэвш уул зэрэг жижиг толгодтой ажээ.

Геологийн тогтоц:

Нүүрсний орд нь Өмнөд Монголын мезозойн рифтийн төгсгөлийн үе шатанд бүрэлдсэн Хөөтийн хотгорт агуулагдана. Нүүрсжилт бүхий дээд юрийн настай хурдас хотгорын төв хэсэгт хуримтлагдсан байх бөгөөд моноклиналь атрианд орсон байна. Ордын баруун хагас нь баруун урдаас зүүн хойшоогоо сунасан синклинали атрианд орсон байх ба түүний урт нь 1.8 км, өргөн нь 300-500 м. Синклиналийн баруун жигүүр нь зүүн урагшаагаа 10-12 градусын налуу, зүүн урд талын жигүүр нь баруун хойшоогоо 4-6 градусын уналтай байна. Энэ жигүүр нь үл ажиглагдах, 3 градусаас ихгүй унал бүхий налуу байрлалтай жигүүртэй синклинали маягийн хотгор структур үүсгэжээ. 1971 онд хийсэн 1:200000 масштабын геологийн эрэл-зураглалын ажлын үр дүнд районы давхрага зүйн ангиллын доод цэрдийн зүүнбаян формацийн элсэн чулуу, алевролит, шатдаг занар зэргээс бүрдсэн доод дэд формац, конгломерат, элсэн чулуу, элс, нүүрс зэргээс бүрдэж буй дээд дэд мэмбэр ялгасан. Харин Л.Мөнхтоогоо литологийн найрлагын онцлогоор нь Хөөтийн ордын талбайд хурдас чулуулгийн харьцаа, амьтан ургамлын үлдвэр зэргээр дотроо 2 мэмбэрт ангилагдах дээд юра, доод цэрдийн 3 формацуудыг ялгасан байна.

Хайгуулын талбайн хэмжээнд литологийн найрлагын хувьд дотор нь дээд юрийн Хамар хөөвөр формацийн 2 мэмбэр, доод цэрдийн Хөх тээг формацийг ангилсан байна.

Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд:

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг нь Далайн түвшнээс дээш 1450 метр өндөрт байрлана. Чулуун нүүрс, хар тугалга, төмрийн хүдэр, гянтболд, усан ба утаат болор, жонш, оюу, гялтгануур майз, номин, цагаан тугалга, алт зэрэг ашигт малтмалтай.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрийг чийг дулааны хангамжийн хувьд 4 мужид, уур амьсгалын хувьд нийтэд нь 4 мужид хуваана. Үүнд:

- ✓ Чийглэг хүйтэн
- ✓ Чийглэгдүү хүйтэвтэр
- ✓ Хуурайдуу хүйтэвтэр
- ✓ Хуурай дулаавтар гэсэн.

Баянжаргалан сумын нутаг нь хуурай дулаавтар мужид хамрагдах бөгөөд энэ муж нь дулааны хангамжаар сайн боловч чийгээр дутмаг учир ургамлын баялгаар муу, газар тариалан эрхлэх боломж муутай юм. Нарны нийлбэр цацраг 1300-1400 кВт цаг/м² буюу нийлбэр цацрагаар Монгол орны дунд бүсэд оршдог.

Гадаргын ус:

Энэ бүс нутаг ус зүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар”-т хамаарах бөгөөд гадаргын усны жилийн дундаж нөөц 0.25 км³ байдаг нь нэн бага хэмжээ юм. Усны гадаргаас уурших ууршил 200 см/жил хүртэл байдаг бол ууршиц 80 см/жил-ээс их байна. Гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага, харин уурших боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг нутаг юм. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 100 мм-ээс бага, үүнээс дулааны улиралд 100 мм буюу түүнээс бага, зөвхөн зарим хэсэгт 100-150 мм, өвлийн улиралд 10 мм-ээс бага хур тунадас тус тус унана.

Гадаргын урсцын жилийн дундаж хэмжээ 1 мм орчим, гадаргын түр урсцын модуль 0.003 л/с,км², гадаргын жилийн нөөцийн хувийн нэгж 0.1 мян.м³/км² тус тус байна. Олон жилийн дундаж урсцын давхраа 25м-ээс бага, 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсцын модуль тус тус 0.1 м³/с км-ээс бага /түр урсгал бүхий гол горхины муж/ байна. Хөөтийн булаг нь жилийн дөрвөн улиралд устай байх боловч цаг уур хуурайших тутамд ус нь татарч багассаар хатдаг байна.

Гидрогеологийн нөхцөл:

Хөөтийн ордын давхарга зүйн ангиллыг доод цэрдийн элсэн чулуу, алевролит, шатдаг занар, дээд юрийн конгломерат, элсэн чулуу, элс, нүүрс зэргээс бүрдэж буй гэж ангилсан байна. Хөөтийн хойт хэсэг буюу нүүрсний ордын хойт талын үргэлжил дээрх хурдасны давхарга зүйн бүтцийг өөрсдийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн литологийн хувьд доороос дээш нь:

1. Конгломератын;
2. Нүүрслэг аргиллитийн;
3. Элсэн чулуулгийн зузаалаг гэж авч үзсэн.

Конгломератын зузаалаг нь судалгаанд хамрагдсан талбайн баруун зах хэсгээр өрөмдсөн КТЕ02, КТЕ11, зүүн захаар өрөмдсөн КТЕ17, КТЕ18 цооногуудад тогтоогдсон бөгөөд КТЕ18 цооног нь конгломератаас нүүрслэг зузаалагт шилжиж буй хэсгийг зүсэж гарчээ. Хайгуулд хамрагдсан талбайн хэмжээнд тархсан терриген гаралтай конгломератын зузаалаг нь баруунаас зүүн тийш нимгэрэх буюу литологийн бүтэц жижиг ширхэгт хурдсанд аажмаар шилжиж байна. Нүүрслэг зузаалгийн хурдас нь судалгаанд хамрагдсан талбайн төв хэсэгт өрөмдсөн бүх цооногт илэрсэн байдаг. Нүүрслэг зузаалгийн нийт зузаан нь энэ ордын хувьд 157.9 м болж байна.

Хөөтийн уурхайн баруун урд хэсэгт 25 м орчим гүнээс газрын доорх ус шүүрч уурхайн олборлолтыг зогсоож, карьерын зүүн талын мөргөцгөөс олборлолт явуулж байна. Карьерын зүүн талд мөргөцгийн гүн газрын доорх усны түвшинд хүрээгүй байгаа бөгөөд 35-45 м орчимд ус шүүрэх магадлалтай.

Хөрсөн бүрхэвч:

Тус Нүүрсний уурхай нь сумын төвөөс баруун урагш 26 км-ийн зайд “Хөөтийн хотгор” нэртэй газарт байрлана. Газрын гадаргуугийн хувьд өндөрлөг толгодоор хүрээлэгдсэн, ухаа гүвээт талархаг шинжтэй, тэгш хөндийн 65.63 га газрыг хамарна. Судалгаанд хамрагдсан энэ газар нь Хөрс-газарзүйн мужлалтаар Говийн их мужийн өргөргийн бүсшилийн цайвар хүрэн хөрсний дэд бүс болох Баяндэлгэрийн 8-р тойрогт багтана.

Газрын гадаргуугийн хувьд нам толгод, гүвээрхэг, долгиорхог тал хөндий, хотос хонхор газрыг хамрах ба 1100-1300м-ийн өндрийн түвшинд хэлбэлзэнэ. Эндэхийн ургамалшил тачир, сийрэг, алаг цоог ургамалтай ба хөнгөн элсэрхэг хөрс давамгайлсан байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсэж эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Уурхайн олборлолт явагдаагүй талбай бүхий газраар нэгэн жигдийн жижиг чулуун болон элсэрхэг хучаастай карбонаттай цайвар хүрэн, сайргархаг болон хужирлаг шинжийн цайвар хүрэн хөрс голлох суурийг эзэлнэ. Хөрсний дээд давхаргын зузаан 30-35 см орчимд хэлбэлзэх бөгөөд түүнээс доош хөрсөнд нэвт нэвчсэн карбонат хуримтлалын давхарга тод илэрнэ. Давсны хүчилд давхаргын нэлээд дээрээс зарим газар өнгөнөөсөө эхэлж бургилт үзүүлнэ. Мөн давслаг чанарын хужирлаг, мараалаг шинж чанарын хөрс хотгор нам газраар алаг цоог тархалттай байна.

Уурхайн олборлолт явуулж байгаа талбайн хөрс нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөнтэй уялдаж, талбайн хөрсний шинж чанарт онцгой өөрчлөлт орсон байна. Тухайлбал талбайд олборлолтын нөлөөгөөр гүн ухагдсан хоосон орон зай үлдэх, хөрсний давхарга алдагдаж, үржил шимт хөрс нь үгүй болох, овоолго үүсэх, дарагдах зэргээр физик, хими чанарын эрс өөрчлөлттэй “Уул уурхайн эвдэрсэн болон талхлагдсан” хөрстэй газар бий болсон байна.

Ургамлан нөмрөг:

Дорноговь аймгийн Баянжаргалан суманд байрлах талбайн хэсэг нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог нь нийт 480 зүйлтэй ба жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн бөгөөд зөвхөн энд ургадаг 9 зүйл тохиолдоно.

Ургамалжлын хувьд Цөлөрхөг хээрт 3 зүйл Хялгана (*Stipa gobica*, *S.glareosa*, *S.brevifolia*), 1 зүйл Хазаар өвс (*Cleistogenes soongarica*), Таана (*Allium polyrhizum*), сөөгнөөс 4 зүйл Харгана (*Caragana pygmaea*, *C.leucophloea*, *C.bungei*, *C.korshinskyi*), Орог тэсэг (*Krascheninnikovia ceratoides*) болон заримдаг сөөгөнцөр шарилжууд (*Artemisia rutifolia*, *A.xanthochloa*, *A.santolinifolia*, *A.pychnoriza*) болно. Бусад заримдаг сөөгөнцөрүүд (*Artemisia frigida*, *A.caespitosa*, *A.xerophytica*, *Anabasis brevifolia*, *Salsola passerina*, *Convolvulus gortschakovii*, *Ajania achilloides*, *A.trifida*, *Reaumuria soongorica*, *Asterthamnus heteropappoides*) дэд зонхилно. Дагуул зүйл ургамлууд нь заримдаг сөөгөнцрөөс *Oxytropis aciphylla*, *Ptilotrichum canescens*, *Kochia prostrata*, алаг өвснөөс *Allium mongolicum*, *Gypsophilla desertorum*, *Convolvulus ammanii*, *Lagochilus ilicifolius*, *Scorzonera divaricata*, *Aster hispidus*, *Asparagus gobicus* зэрэг бол, цөөн настаас *Salsola pestifera*, *S.collina*, *Artemisia scoparia*, *Neopalassia pectinata* зэрэг ургамлууд болно.

Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлөрхөг хээрийн ургамалжилтай бөгөөд бүхэлдээ 1 хэв шинжид хамаарах 1 бүлгэмдэл тархсан байна.

Амьтны аймаг:

Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэгдэх Хөөт-3 нүүрсний ордын бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна.

Монгол дагуурын хээрийн тойрогт жижиг хөхтнөөс үлийн цагаан оготно, дагуур огдой, дагуурын зурам, монгол чичүүл, туруутнаас аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр, мах идэшт амьтдаас хотны үен, өмхий хүрнэ, хярс үнэг, шар үнэг зонхилно (Банников, 1954). Монгол дагуурын хээрийн тойргийн амьтны зүйлийн бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр, зарим зонхилгоч зүйл амьтдын биологи экологийн нарийвчилсан судалгааны дүнд 4 багийн, 14 овгийн, 54 зүйлийн шавж (Murdoch et al., 2006); 1 баг, 4 овгийн 7 зүйл мөлхөгч (Reading et al., 2006a); 14 баг 30 овог, 185 зүйлийн шувуу (Reading et al., 2011); 7 баг 15 овог 28 төрөлд хамаарах 39 зүйлийн хөхтнийг тэмдэглэсэн байдаг (Reading et al., 2013 in press).

Нийгэм-эдийн засаг:

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь 1923 онд байгуулагдсан. Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төвөөс 150 км, Говьсүмбэр аймгаас 80 км зайтай. Өөрийн аймгийн Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдтай, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг. Тус сум нь байгалийн баялаг хүрэн нүүрс, занар, жонш, төмрийн хүдэр, уран, өнгөт металл, шаазангийн шавар, цементийн материалаар элбэг. Өнөөдрийн байдлаар тус суманд ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Засаг Даргын Тамгын газар зэрэг төрийн үйлчилгээний байгууллагууд үйл ажиллагаа явуулахаас гадна Аргатай, Сэрвэнгийн булаг, Дэлгэрэхийн баянзалаат, Түрүүгийн булаг зэрэг худалдаа, нийтийн хоолны, Бор дарс, Боржигон-Эрдэнэ гэсэн мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний хувийн хэвшлийн салбарууд, блокны үйлдвэр мужаан, гутлын, оёдлын, өнгөт хэвлэлийн үсчин зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд, мөн ХААН банк, Хадгаламж банкны тооцооны төвүүд зэрэг байгууллага аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

Сумын төвд “МЦХ” ХК-ийн харьяа холбооны салбар байхаас гадна Мобиком, Юнител, Жи-Мобайл компаниудын үүрэн телефоны үйлчилгээтэй. Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1988 онд баригдсан 110/35/10 кВт-ийн дэд станцтай бөгөөд сумын төвд ундны усны худагт зөөлрүүлэх төхөөрөмж тавигдсан.

“Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэгдэх Хөөт-3 ордыг ил аргаар ашиглах” төсөл хэрэгжих талбай нь Энгэр-Ус II-р багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг. Тус баг нь 161 өрхийн 467 хүн амтай. Тусгай зөвшөөрлийн талбайн орчин нь хүн амын суурьшлын хувьд сийрэг, 1 км² нутагт 0.5-1.0 хүн ноогдох ба нутгийн иргэд нь гол төлөв мал аж ахуй эрхэлж хонь, ямаа, цөөвтөр тооны үхэр, адуу, тэмээ үржүүлдэг байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэлжлэх хугацаа

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг билээ. Энэхүү арга нь нүүрс олборлох үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурлан, нөлөөллийн үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодорхойлохыг зорьсон ба хэрэв ямар нэг нөлөөлөл байгаа гэж үзэх юм бол “х”-ээр тэмдэглэнэ.

Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Будалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт	х				х		х		х	
Гадаргын усны урсцын өөрчлөлт		х			х		х		х	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	х				х		х		х	
Зэрлэг амьтдын орон зай		х			х		х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
2.Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	х				х		х	х		
Бэлчээрийн байдал	х				х	х				
Эрдэс түүхий эдийн нөөц	х									
Эрчим хүчний нөөц		х			х					х
3.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газар доорх усны чанарын өөрчлөлт	х				х	х				х
Гадаргын усны чанарын өөрчлөлт		х			х	х			х	
Агаарын бохирдол		х		х		х				х
Хөрсний бохирдол	х			х		х			х	
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө		х		х		х				х
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	х				х		х		х	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х		х		х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		х								х

5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Орон нутгийн орлого нэмэгдэх	х				х	х			х	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х				х	х			х	
Ажлын байр нэмэгдэх	х				х	х			х	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх			х							
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		х		х		х				х
6.Бусад нөлөөлөл										
Барилга байгууламжийг барих, өргөтгөх үед орчны хөрсний эвдрэл, бохирдол гарах	х			х			х			х
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорх усыг бохирдуулах		х		х			х			х
Ахуйн хог хаягдал, барилгын материалын хаягдал зэргээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх		х		х			х			х
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга		х		х		х				х
Дүн	15	11	2	8	16	10	13	2	11	11

“Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэгдэх Хөөт-3” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг 6 бүлэг 31 асуулгыг магадлан жагсаан үргэлжлэх хугацаа, нөлөөллийн эрчим, болон буцалтгүй болон буцаж нөлөөлөх нөлөөлөл зэргийг тус тус тогтоон дээрх хүснэгтэд үзүүллээ. Иймд тэдгээрт задлан шинжилгээ хийж дараах дүгнэлт өгч болох юм. Үүнд:

Шууд ба шууд бус нөлөөлөл, түүний эрчим:

Болзошгүй нөлөөллийн 15 нь шууд нөлөөлөлд 11 нөлөөлөл нь шууд бус нөлөөлөлд хамаарагдаж байна. Шууд нөлөөлөлд газрын доорх усны өөрчлөлт, түүний нөөцийн хомсдол, бохирдол, хөрсний элэгдэл эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, бэлчээрийн хомсдол, байгалийн үзэсгэлэнт төрхийн өөрчлөлт гэх мэт нөлөөллүүдэд сөргөөр орон нутгийн орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болох зэрэг нөлөөллүүдэд эергээр нөлөөлж байна. Шууд бус нөлөөлөлд гадаргын усны урсцын өөрчлөлт, зэрлэг ан амьтны амьдрах орчин, эрчим хүчний нөөц, агаарын бохирдол, дуу шуугиан, хүн амын эрүүл мэнд, байгалийн онц аюултай үзэгдэл зэрэг нөлөөллүүдэд шууд бусаар нөлөөлж байна. Харин эрчимшлийн хувьд 2 нөлөөлөл хүчтэй, 11 нөлөөлөл дунд 11 зүйл нөлөөлөл нь бага зэргийн нөлөөлөлтэй байна.

Нөлөөллийн хугацаа: Энд 16 нөлөөлөл нь урт хугацаагаар, 8 нь богино хамаарагдаж байна. Үүнээс ордын ойр орчны ургамлын нөмрөг алдагдаж устах, хөрс эвдрэх, унд ахуйн хэрэглээнд газрын доорх ус авч ашиглах тул түүний нөөц, урсцын горимд өөрчлөлт гарах, ус ба хөрсний бохирдолт үүсэх зэрэг нь эргэж сэргэхдээ маш удаан хугацаа шаардагддаг онцлогтой тул урт хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна.

Дээрх байдлаас үзэхэд “Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэгдэх Хөөт-3” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа нэлээд удаан, эрчмийн хувьд 2 нөлөөлөл хүчтэй, 11 нь дунд зэрэг 11 нөлөөлөл нь бага байгаа нь нөхөн сэргээх, үүссэн сөрөг нөлөөг багасгах арилгах асуудлыг төслийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажилтай нарийн уялдуулан хийж байх нь зайлшгүй болно.

3.2. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Ашигт малтмал ашиглалтын MV-020899 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд хэсэг дэх Хөөт-3” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн байршил, техник-технологийн шийдэл, төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” (checklists) аргыг хэрэглэн үр дүнг нь хүснэгтэд илэрхийлэв.

Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

Байгаль орчны асуудлууд	Гол нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Бага /муу/	Дунд	Их /сайн/
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудлууд				
Голын гольдрилыг өөрчлөх, эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх	х			
Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах	х			
Ой модыг огтлох явдал гарах	х			
Түүх, соёлын дурсгалт газрыг эвдэхэд хүрэн	х			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	х			
Бүс нутгийн үерийн болон булаг, шанд хатах, ширгэх аюул гарах		х		
2. Үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төсөөллийг багтаасан төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, нүүрс олборлох болон бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			х	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс сэргийлэн хамгаалах болон ажилтнууд хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хэрхэн төлөвлөгдсөн			х	
Нүүрс олборлох үед болон уурхайгаас гарах грунтын уснаас хамгаалах, хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой		х		
Шүүрлийн усыг зайлуулах, хуримтлуулах нуурын технологийн шийдэл		х		
Тоосжилт дарахад ашиглах технологийн шийдэл		х		
Уурхайн үйл ажиллагааны үед гарах шуугианыг тогтоосон хэмжээнээс багасгах тухай төсөлд тусгагдсан эсэх		х		
Тусгай анхаарал тавих шаардлагатай шороо, тоос, утаа гардаг эсэх	х			
3. Барилга байгууламжийн хийц, барихтай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Барилга байгууламжийг барих үед усны нөөц бохирдох байдал	х			
Барилга байгууламжийг барих үеийн болон барьсны дараах хөрсний эвдрэл, элэгдэл		х		
Ажиллагсдын төрөл бүрийн аваар, осолд өртөх байдал, хортой нөхцөл, халдварт өвчин гарах		х		

4. Төслийн үйл ажиллагааны үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				х
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
